

## Таны орогнол эрсэн өргөдөл болон давж заалдсан бүх гомдолд татгалзсан хариу өгсний дараа өгөх тусламж, орон байр

Таны орогнол эрсэн өргөдлийн талаар Home Office\* шийдвэр гаргаагүй буюу таны давж заалдсан гомдлыг хянан шийдвэрлээгүй байгаа тохиолдолд та NASS\*-аас тусламж авах эрхтэй байж болно. Таны орогнол эрсэн өргөдөл болон давж заалдсан бүх гомдолд татгалзсан хариу өгсөн тохиолдолд танд өгөх тусламж өөрчлөгдөж магадгүй.

## Миний орогнол эрсэн өргөдөл болон давж заалдсан бүх гомдолд татгалзсан хариу өгсөн үү?

Та үүнийг сайн мэдэхгүй байгаа буюу таны эх орон дахь нөхцөл байдал өөрчлөгдсөн бол аль болох даруй хууль зүйн зөвлөгөө авах хэрэгтэй - өмгөөлөгчөөсөө зөвлөгөө авах буюу хэрэг хариуцсан ажилтнаас өмгөөлөгчдийн жагсаалт хүсэх хэрэгтэй.

## Таны орогнол эрсэн өргөдөл болон давж заалдсан бүх гомдолд татгалзсан хариу өгсний дараа өгөх тусламж

Таны орогнол эрсэн өргөдөлд татгалзсан хариу өгсөн бол байр, тусламж авахад хэцүү болж болно. Гэхдээ хэдэн боломж бий:

### 1. 95-р хэсгийн тусламж – таны орогнол эрсэн өргөдлийг шийдвэрлэх явцад авах тусламж

- Та S95 NASS\* тусламж авах хугацаагаа дуусахаас өмнө 18-аас доош насны хүүхэдтэйгээ хамт амьдарч байсан бол таны бүх хүүхдийг 18 хүртэл энэ тусламжийг өгсөөр байх болно.
- Хэрэв та хүүхэдгүй бол, таны орогнол эрсэн өргөдөлд татгалзсан хариу өгснөөс хойш 21 хоногийн дараа NASS S95\* тусламжийг зогсооно. NASS\* танд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

### 2. 4-р хэсгийн тусламж –байр, хоолны үндсэн зардал, буюу ваучер.

- NASS S95\* тусламж авах хугацаа тань дууссаны дараа хүүхэдтэй болох буюу эх орондоо сайн дураараа буцах хүсэлт гаргасан тохиолдолд та 4-р хэсгийн тусламж хүсэх эрхтэй болно. Дэлгэрэнгүй мэдээлэл үзье гэвэл Section 4\* тусламжийн тухай “Refugee Action”\*-ы танилцуулгыг үзнэ үү.

### 3. Орон нутгийн засаг захиргааны үзүүлэх тусламж

- Хэрэв та биеийн/ сэтгэцийн эрүүл мэндийн хувьд ноцтой хүндрэлтэй эсвэл ахмад настай/өвчтэй бол Local Authority\* танд байр, тусламж олгож болно. Үүний тулд тэд таны нөхцөл байдлыг судлах хэрэгтэй болно. Үүнийг Community Care Assessment\* гэдэг бөгөөд хэдэн долоо хоног шаардагдаж болно.
- Та хүүхэдтэй боловч S95, S4 тусламж авах боломжгүй бол Local Authority таны хүүхдүүдэд тусламж олгох ёстой. Гэхдээ 18-аас дээш насны гэр бүлийн гишүүдэд тусламж олгохоос татгалзаж болно.

**Хэрэв та дээрх ангиллын алинд нь ч багтахгүй бол байр, хоол хүнс, хувцас олоход тань туслах орон нутгийн байгууллагууд байж болно.**

**Асуух зүйл байвал хэрэг хариуцсан ажилтанд хандана уу.**

\* Эдгээр нь байгууллагуудын англи нэрс буюу орчуулж болохгүй бусад үгс юм. Эдгээр нь юу гэсэн үг болохыг зөвлөгөө өгдөг ажилтнаас асууна уу.